



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 5.2

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 176,220.38 (нэг зуун далан зургаан сая хоёр зуун хорин мянга гурван зуун наяд) мянган төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

2.1. Компанийн батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэн, тухайн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

2.2. “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах;

3. “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Минжинхүү)-д Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 4.2-ийг ханган ажиллаж, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай;

3.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;

3.2. Ашиглалтгүй байгаа соёл хүмүүжлийн төвийн барилгад мэргэжлийн байгууллагын зохих дүгнэлтийг гаргуулан, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, төрийн өмчийн ашиглалтын талаар арга хэмжээ авч ажиллах;

3.3. Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй шугам хоолойн хөрөнгөд хийх их засвар, шинэчлэлт сайжруулалт, болон засварын ажлаас буусан үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тухай бүр зөвшөөрөл авч байх, компанийн хашаанд ашиглалтгүй байгаа шугам хоолойг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хоёрдогч түүхий эдээр үнэ тогтоон, худалдан борлуулах арга хэмжээ авах;

3.4.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхийг хориглоно гэж заасны дагуу насжилт өндөртэй, он удаан жил хадгалагдсан бараа материалын хадгалалт, ашиглалтын хугацаа, хэрэглээний байдалд дүн шинжилгээ хийж, үнэ тогтоон худалдан борлуулах, акталж данснаас хасах, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;


3.5.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээгээр олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах;

3.6.Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах;

3.7.Батлагдсан хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авахгүй байх, үйл ажиллагаандаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

3.8.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА		Б.ЦЭНГЭЛ
ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА		Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2024 оны 02 дугаар сарын 06-ны
өдрийн 53 дугаар тогтоолын хавсралт

**“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИД ХИЙСЭН БАРИМТЫН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ,
ТҮҮНИЙГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Дүн /мян.төг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлээгүй худалдан авалт	116,703,780.00	Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгадаж, батлагдсан зардлыг хэтрүүлсэн худалдан авалт	26,576,600.00	Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах
3	Хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажиллах тухай Эрчим хүчний сайдаас өгсөн удирдамж, чиглэлийг зөрчсөн	15,000,000.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, ТУЗ-өөс Гүйцэтгэх захиралтай байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г мөрдөж ажиллах
4	Эрх бүхий байгууллагын шийдвэргүй худалдан авалт	17,940,000.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан “Төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах” эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр
	Дүн	176,220,380.00	(нэг зуун далан зургаан сая хоёр зуун хорин мянга гурван зуун наяд) төгрөг